



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 1/32

Мандалговь

Төсөл, хөтөлбөр арга хэмжээний
жагсаалт батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 11 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 02-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 11 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 4.3-т батлагдсан "Хөтөлбөр арга хэмжээ /аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх/-ний 14,830,000 /арван дөрвөн сая найман зуун гучин мянга/ төгрөгийн төсөл, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Хавсралтанд нэр заагдсан төсөл, хөтөлбөр арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/-т, ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

020000659

Аймгийн Засаг даргын 2017 оны
02 дугаар сарын 23 ны өдрийн
11/32 тоот захирамжийн хавсралт



Төсөл хөтөлбөрийн жагсаалт

№	Төсөл хөтөлбөрийн нэр	төсөвт өртөг
1	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж нийлүүлэх, тохижилтын ажил	7,510,000
2	Төрийн байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааг ТББ-аар үнэлүүлэх	740,000
3	Бизнес эрхлэгч иргэдийг дэмжих хөтөлбөр	1,000,000
4	"И-офисс" хөтөлбөр	5,580,000
Нийт дүн		14,830,000

